



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1996 оны 02 дугаар сарын 08 өдөр

Дугаар А/43


Улаанбаатар хот

24 цагийн үйлчилгээтэй хүнсний дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх тухай

1. "Дүүргүүдэд 24 цагийн үйлчилгээтэй хүнсний дэлгүүр ажиллуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 1995 оны А\255 тоот захирамжийг хэрэгжүүлснээр гарч буй үр дүн болон дүүргүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн хавсралтад дурдсаны дагуу 24 цагийн үйлчилгээтэй хүнсний дэлгүүрийн тоог нэмэгдүүлсүгэй.

2. 24 цагийн үйлчилгээтэй хүнсний дэлгүүрүүд нь ердийн хуваариар ажилладаг дэлгүүрүүдийг хаасан цагаас нээгдэх хүртэлх хугацаанд эх орны үйлдвэрийн баталгаатай архи худалдаалж байхыг холбогдох компанийн удирдлагуудад үүрэг болгосугай.


3. Дэлгүүрүүдийг үйлчилгээний дэг журмыг чанд мөрдүүлэн ажиллуулахыг холбогдох компанийн удирдлагуудад, журамын биелэлтэнд хяналт тавьж, зөрчил гаргасан дэлгүүрийн 24 цагаар үйлчилгээ явуулах эрхийг хасах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэрлэл, үйлчилгээний алба (н.Болд), Дүүргүүдийн Засаг дарга нар, Хотын цагдаагийн газар (н.Амарболд) -т тус тус үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
Б.Г.ЭВЭН УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

*Ц.Баасанжав*

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн Засаг даргын 1996 оны  
 8/12 тоот захирамжийн хавсралт

ДУУРГУУДЭД 24 ЦАГААР АЖИЛЛАХ  
 ХҮНСНИЙ БАГААНЫ ДЭЛГҮҮРҮҮДИЙН

Дүүргийн нэр : Аж ахуйн нэгжийн нэр : Дэлгүүрийн байршил

1. Баянгол	"Наранбулаг" ББХК-ний хүнсний дэлгүүр	4 дүгээр хороолол Ахуй үйлчилгээний ордны урд талд
2. Баянзүрх	"Баянцээл" ББХК-ний үйлчилгээний төв	I5-р хороололд
3. Хан-Уул	"Өрнөлт-3" ХЭАА-н хүнсний дэлгүүр	120,0 мянгатад
4. Сүхбаатар	"Хүннү" ББХК-ний хүнсний дэлгүүр	Тээврийн товчооны дэргэд